

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2022.10.04

Сүхбаатар сум

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаан 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

1. 2022-2023 оны хичээлийн жилийн явцын мэдээлэл
2. Хүүхдийн ордон, хүүхэд хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний мэдээлэл
3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хүсэлтэд санал өгөх
4. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох, худалдах хөрөнгийн доод үнийг тогтоох тухай
5. Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай
6. Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай
7. Бусад асуудал зэргийг хэлэлцлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн дарга, гишүүд аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Эрүүл мэндийн дэмжих төв”-ийн үйл ажиллагаатай танилцлаа.

Тус төв нь ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэлтэй болгох, хувь хүн, байгууллага хамт олны багц үзлэг оношилгоо, шинжилгээ, тусламж үйлчилгээг иж бүрэн үзүүлэх төв юм.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “G9198/9221-МОН: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийг 2019 оноос хэрэгжүүлж, төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийг түр хамгаалах жишиг байр байгуулахаар төлөвлөсний дагуу Сэлэнгэ аймагт байгуулсан 8 ортой түр хамгаалах байрыг орон нутагт албан ёсоор хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гүнждагва, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа, аймгийн Цагдаагийн газрын дарга Б.Ганхуяг, төсөл хэрэгжүүлэх нэгжийн төлөөлөл, албаны бусад хүмүүс оролцлоо.

Төслийн 301.0 сая төгрөгийн санхүүжилтээр өргөтгөл, засвар, иж бүрэн тохижилтыг хийж, орон нутагт хүлээлгэн өгч байгаа бөгөөд цаашид энэхүү Түр хамгаалах байрны үйл ажиллагаа, урсгал зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тогтвортой байдлыг хангаж ажиллахаар шийдвэрлэлээ.

Энэхүү төвийн үйл ажиллагаанд 2022 онд 54.9 сая төгрөгийг төсөвлөн ажиллаж байна.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх манай аймагт айлчилж, Хушаат сум дахь “Өгөөж Мандал Уул” ХКК-ий ургац хураалтын явцтай танилцаж, тариалангийн талбайн ойн зурвас, мод үржүүлгийн төвд ажиллаж, тариаланч, ногоочдын санал хүсэлтийг хүлээн авлаа.

Аймгийн хэмжээнд үр тариа хураалт 32, төмс, хүнсний ногооны хураалт 60 хувьтай байна. 09 дүгээр сарын байдлаар манай тариаланчид 55 мянган тн улаанбуудай, 964 тн тэжээлийн ургамал, 4 мянган тн тосны ургамал, 15 мянган тн төмс, 20 мянган тн хүнсний ногоо хураан аваад байна.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарар ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ аймагт ажиллаж

- Сүхбаатар, Алтанбулаг сумын айл өрх, төсөвт газар, аж ахуйн нэгжийг дулаанаар ханган ажиллах шинээр дулааны цахилгаан станц барих;
- Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн дагуу “Жишиг сум” төслийн хүрээнд чөлөөт бүс рүү дэд бүтэц татах, цахилгаан, дулаан хангамжийн өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх, бохир, цэвэр усны шугам сүлжээг ашиглалтад оруулах, хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх;
- Шаамар сумын хэмжээнд хүлэмж барих 600 сая төгрөгийн хүсэлтийг шийдвэрлэх;
- Газар тариалан, хүнсний ногоо үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлж ирэх оны төсөвт 285 тэрбум төгрөгийг тусгах асуудлуудыг шийдвэрлүүлээ.

2022-2023 оны хичээлийн шинэ жилийн нээлт Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 7 дугаар сарын 11-ний өдрийн 159 дүгээр зарлигаар Төрийн бүх байгууллага, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах ёслолтой хамтатган аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж, аймгийн удирдлагууд аймгийн төв Сүхбаатар сумын сургууль, цэцэрлэгүүдийн нээлтийн үйл ажиллагаанд оролцож, Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүлээлгэн өгч, багш, сурагч, эцэг эхчүүдэд баярын мэндчилгээ дэвшүүллээ.

Сэлэнгэ аймгийн Ерөө суманд “Монголын Алт” компани нийгмийн хариуцлагын хүрээнд 11.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Олон Улсын стандартад нийцсэн 960 хүүхдийн багтаамжтай 3 давхар, эко сургууль барьж, ашиглалтад хүлээлгэн өглөө. Тус сургууль нь Монгол орны 330 сумдаас анхны Олон Улсын стандартад нийцсэн сургууль болж байгаагаараа онцлогтой юм. Уг сургуульд тулгуур эрхтний бэрхшээлтэй 1 хүүхэд суралцахаар болсон тул лифттэй болгосон байна.

Монголын Зохиолчдын эвлэлийн Сэлэнгэ аймаг дахь салбар үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд 5 аймгийн зохиолчдын дунд “Өргөн Сэлэнгэ” яруу найргийн наадам зохион байгуулагдлаа. Наадамд Булган, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн найрагчид оролцож, Тэргүүн байранд Сэлэнгэ аймгийн яруу найрагч Д.Отгонцагаан, Хоёрдугаар байрыг Хөвсгөл аймгийн яруу найрагч О.Элбэгтөгс, Гуравдугаар байрыг Хөвсгөл аймгийн яруу найрагч Ц.Гончиг, Тусгай байранд Хөвсгөл аймгийн яруу найрагч Ш.Бадамрагчаа, Булган аймгийн яруу найрагч Т.Амар-Амгалан нар тус тус шалгарлаа.

Аймгийн Онцгой байдлын газартай “Урсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага, сургууль”-ийг Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар, Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, алба хаагчдад урсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагааны анхан шатны мэдлэг олгох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, шинээр томилогдсон алба хаагчдад уснаас эрэн хайх, аврах ажиллагаа, нэрвэгдэгчид тусламж үзүүлэх болон дадлага эзэмшүүлэх зорилгоор зохион байгууллаа. Дадлага, сургуульд Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар,

аймгийн Цагдаагийн газар, Хилийн 0101, 0243 дугаар ангийн нийт 50 гаруй алба хаагч хамрагдлаа.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хөрөнгө оруулагч Азийн хөгжлийн банкны 6.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа өргөтгөл, шинэчлэлийн ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Монкон Констракшн” ХХК ажиллаж байгаа бол туслан гүйцэтгэгчээр “Цэлмэг очир констракшн” ХХК, “Хан Халдун” ХХК, “Хайберид” ХХК зэрэг компаниуд ажиллаж байна. Уг ажлын явцтай аймгийн Засаг дарга танилцаж, чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийг ажиллуулж нөхцөл байдлыг үнэлүүлэн, алдаа дутагдлыг арилгуулах, засаж сайжруулах талаар ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж үүрэг чиглэл өглөө.

Аймгийн Засаг даргын Тамгын газар “PlanetGOLD” Монгол төсөлтэй хамтран “Бичил уурхайн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй ба Эрх зүйн орчин” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймаг, сумын Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүд, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Байгал орчин, аялал жуулчлалын газар, Баянгол, Мандал сум Түнхэл тосгоны захирагчийн төрийн албан хаагчид хамрагдлаа.

Оролцогчид энэхүү сургалтаар алтны бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагууд, бичил уурхай дахь эрсдэлүүд, түүнийг үнэлэх, химийн хорт бодисын нөлөө, төрийн болон бичил уурхайн байгууллагуудын хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын талаар нэгдмэл ойлголтыг авлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” хөтөлбөрийн хүрээнд “Эрэг сэтгэлгээний давлагаа” ТББ-тай хамтран “Эрэг сэтгэлгээ-Хувь хүний цогц хөгжил” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын нийт 39 албан хаагч хамрагдаж “Эрэг харилцаа”, “Харилцааны 5 зарчим”, “Өөрийгөө бүтээх нь”, “Эрэг хандлага”, “Гоо зүйн боловсрол”, “Илтгэх ур чадвар”, “Жинхэнэ манлайлал”, “Бүтээлч сэтгэлгээ”, “Өөртөө эргэлзэх ур чадвар” зэрэг сэдвийн хүрээнд мэдлэг, мэдээллийг авч, дадлага ажлаар баталгаажуулан сургагч багшаар бэлтгэгдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын дэмжлэгтэйгээр БНСУ-ын Үньпён дүүргийн төлөөлөгчид албан айлчлал хийж, айлчлалын хүрээнд Сэлэнгэ аймаг БНСУ-ын Үньпён дүүрэгтэй хамтран ажиллахаар боллоо. Энэ үеэр аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж Бүх иргэдэд маань боломж олгосон үр дүнтэй харилцан хамтын ажиллагаа байна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийллээ.

Монгол Улсын хэмжээнд өрнөж байгаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Сэлэнгэ аймаг нийлүүлэгч аймаг болох эрхэм зорилготойгоор оролцож байгаатай холбогдуулан Монгол Улсын баатар Ж.Нэхийтийн нэрэмжит Хилийн цэргийн 0101 дугаар ангийн удирдлага Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хугацаат цэргийн албан хаагчдаа Байгаль орчин, аялал жуулчлалын салбар дахь ойжуулагч мэргэжлийн сургалтад хамруулан төгсгөж мэргэжилтэй болгох ажлыг амжилттай зохион байгуулж байна. Тус анги нь “Тавт” мод үржүүлгийн агропарк байгуулж, ойжуулагч мэргэжлийн сургалтад хамрагдсан хугацаат цэргийн албан хаагчид болон, ангийн нийт бүрэлдэхүүн 1.5 га газарт нарс 90000 ширхэг, бургас 75000

ширхэг, улиас 45000 ширхэг, агч, хайлаас, буйлс зэргийг үрийн тариалалтаар тус тус тарьж бойжуулаад байна.

Мөн бусад агропарк болон, хил хамгаалах байгууллагын ангиудад модны үр, харандаан суулгац зэргийг бэлтгэн нийлүүлээд байгаа юм.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Эрүүл мэндийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ төрийн үйлчилгээг ойртуулах, төрийн албан хаагчдыг орон нутагт нь мэргэшүүлэн сургаж дадлагажуулах, ажлын байран дээр нь хөгжүүлэх үндсэн зарчмын дор “Шидэт гар” дохионы хэлний сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 17 сум, хэлтэс, агентлагийн мэргэжилтнүүд хамрагдаж, дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй боллоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Хууль зүйн үндэсний хүрээлэн, Ханнс Зайделийн сантай хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд сумдын эрх зүйн хөтөч, байгаль орчны салбарын нийт 80 гаруй алба хаагчдыг чадавхжуулах сургалтад хамрууллаа.

#### **Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабаас дэлхийн дахинд тархаад буй коронавирус (Ковид-19)-ын халдварын тохиолдол гарч, халдварлах эрсдэл бий болсонтой холбоотойгоор урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр Онцгой комиссын орлогч, Шуурхай штабын дарга, аймгийн Засаг даргын орлогч Ц.Рэгзэдмаагаар ахлуулсан Онцгой байдлын газрын 7, Цагдаагийн газрын 1, Мэргэжлийн хяналтын газрын 4, Эрүүл мэндийн газрын 1 нийт 13 албан хаагч өглөөний **09:00-21:00** цаг хүртэл ажиллан аймгийн Онцгой комиссын даргаас хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар өгсөн үүрэг чиглэл, мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээллийг хүлээн авч холбогдох шийдвэрийг гаргаж, сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын даргаас хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар өгсөн үүрэг чиглэл, мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээллийг хүлээн авч холбогдох шийдвэрийг гаргаж, сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шуурхай штаб нь **70363684, 70360119** дугаарын утсанд мэдээлэл хүлээн авч ажиллаж байна.

Аймгийн албан ёсны цахим хуудас болон Онцгой байдлын газрын цахим хуудсанд Онцгой байдлын газар, “Дэлхийн Зөн Монгол” Олон Улсын байгууллагатай хамтран “Яагаад амны хаалт зүүх ёстой вэ?”, “Гараа яагаад угаах ёстой вэ?”, “Хамтын хүчээр халдвараас сэргийлье”, “Ковидгүй Сэлэнгийн төлөө” шторк, аймгийн Онцгой комиссын мэдээ, мэдээллийг байршуулж, **350** хандалт авсан.

Мөн аймгийн Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар Коронавирусын эсрэг 20 төрлийн мэдээлэл, сургалт сурталчилгааг нийт 8593 хүнд хүргэж, бусдад хуваалцсан 985, дэмжсэн 158 иргэн байна.

Аймгийн хэмжээнд коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын 1 дүгээр давлагаанд **217**, 2 дугаар давлагаанд **4849**, 3 дугаар давлагаанд **13783**, 4 дүгээр давлагаанд **10024** нийт батлагдсан тохиолдол **28873** байна. Дотоодын нийт халдварын 30.8 хувь (8883) нь аймгийн төвд 69.2 хувь (19990) нь бусад орон нутагт бүртгэгдсэн байна. 2022 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 79 батлагдсан тохиолдол гарсан бүгд

түргэвчилсэн шинжилгээгээр батлагдсан байна. 09 дүгээр сарын байдлаар 0-17 насны 7 хүүхэд өвдсөн бөгөөд нийт батлагдсан тохиолдлын 8,8 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2 эмнэлгийн 2 тасагт 5 хүн эмчлэгдсэн. Үүнээс 0-17 насны 3 хүүхэд эмчлэгдсэн байна.

Дархлаажуулалтад өссөн дүнгээр I тун **70473**, II тун **66438**, III тун **37462**, IV тун **7216** тус тус хийгдээд байна.

**Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:**

Тайлант хугацаанд объектын гал түймрийн 8, аврах ажиллагааны 2, эрэн хайх 2, ой, хээрийн түймрийн 2, хээрийн түймрийн 1, усны ослын 1 нийт 16 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч 2 иргэний амь насыг авран хамгаалж ажиллалаа.

“Цаг агаарын нөхцөл байдал хүндэрч зам даваа хаагдах эрсдэл үүсэхэд зам засвар хийгдэж байгаа автозамын компаниудын хүч хэрэгсэл, машин техникийн үзлэг шалгалт хийх” удирдамжийн хүрээнд Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газартай хамтран Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамын өргөтгөл төслийн 4 дүгээр багцын Европын сэргээн босголтын банк, Азийн хөгжлийн банкны төслийн Төв аймгийн Сүмбэр сумаас Дархан-Уул аймгийн Хонгор сумын Цайдамын даваа хүртлэх 45.02 км замын ажлыг хийж гүйцэтгэж байгаа “Шанхай констракшн групп Монголиа” ХХК, “Чайна гео инженеринг корпораци” ХХК-ий удирдлагууд, автозамын ажил хийгдэж байгаа хэсгүүдийн нөхцөл байдалтай танилцаж ажилласан.

Хяналт шалгалтын ажлын мэдээг нэгтгэсэн дүн:

Шалгалтад хамрагдсан объектын тоо	Зөрчил		Захиргааны арга хэмжээ		Заавал биелүүлэх албан шаардлагын тоо	Албан мэдэгдлийн тоо	Танилцуулгын тоо	Ажиллагаа зогсоох тогтоолын тоо	Сургалт, дадлага, зааварчилгааны тоо хүн/цаг	Хэвлэл мэдээллээр сурталчилсан тоо
	Илрүүлсэн зөрчлийн тоо	Шалгалтын явцад арилгуулсан зөрчлийн тоо	Арга хэмжээ авагдсан субъектын тоо	Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
27	164	69	-	-	17	4	-	-	31 ажилтан 1 цаг лекц	1

Тайлант үед 2 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж зөрчлийг арилгасан 2 объектод ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож 25,000 төгрөг, Төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн барилга байгууламжийн 14 ажлын зургийг хянаж, баталгаажуулан, дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэн 700,000 төгрөгийн хураамжийг тус тус аймгийн төрийн сангийн дансанд тушаалгаж ажилласан.

**Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллежуудын 2022-2023 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажил, салбарын хууль түүнд нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 17

сум 6 тосгоны ерөнхий боловсролын 35 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 40 байгууллага, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 2 төв нь 1 дүгээр үе шатны шалгалтаар 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн бэлэн байдал сургуулийн өмнөх боловсролын байгууллага дунджаар 90.0 хувьтай, ерөнхий боловсролын сургууль дунджаар 82.9 хувьтай тус тус хангагдсан бөгөөд удирдамжид тусгагдсаны хүрээнд 2 дугаар үе шатны хяналт шалгалтын явцад эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 1.10.4 кодтой хяналтын хуудсаар Мандал, Баянгол, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумдын ерөнхий боловсролын 7 сургуулийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийхэд их эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 4, бага эрсдэлтэй 2, дунджаар хууль сахин мөрдөлт 67.7 хувь, эрсдэл үүсэх магадлал 32.3 хувьтай тус тус үнэлэгдсэн.

Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор худалдаалж буй шинэ ургацын ногоо, жимс жимсгэнэ тариалагч, худалдан борлуулагч 80 иргэний нийт 354 сорьцод нитрат, пестицидийн үлдэгдэл, ургамлын өвчин, хортон шавж тодорхойлох шинжилгээ хийснээс 1 аан, 2 иргэний 3 сорьц нитратын үлдэгдэл зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр, 1 иргэний 2 сорьцод ургамлын өвчин илэрсэн бөгөөд дотоод хяналтаар газар дээр нь устгуулсан, нийт 249 сорьц шаардлага хангаад байна.

Зүүнбүрэн сумын 2 дугаар баг 800 тоотод байрлах “Оюут Сүрэг” ББН дэргэдэх малын эмийн сан, Сүхбаатар сумын 6 дугаар багт байрлах “Арвин Ерөө” ХХК, 4 баг Олон Улсын худалдааны төвд байрлах “Чонос бүргэд” ХХК, “Цацад” ХХК малын эмийн сангуудыг үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамруулж эрсдэлийн үнэлгээг хийж, улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлж биелэлтийг тооцож ажиллахаар шийдвэрлэлээ.

#### **Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:**

*Үйлчилгээний баталгаажуулалт:* Сүхбаатар, Баянгол, Мандал сум, Түнхэл, Хэрх тосгон, Алтанбулаг сумдын 38 иргэн, аж ахуйн нэгжийн 9 минимаркет, 1 ая тухтай дэлгүүр, 20 хүнсний дэлгүүр, 1 хүнсний мухлаг, 3 зоогийн газар, 4 кафе, 1 караоке үйлчилгээ, 1 цайны газар, 2 зочид буудал, 1 халуун ус, үсчний газрын нийт 43 үйлчилгээний газарт “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019”, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Караокед тавих ерөнхий шаардлага MNS 6909:2021”, “Халуун усны үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5163:2002”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Үс засах үйлчилгээнд тавих шаардлага MNS 5160:2020” стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаагаар сунгав.

*Бүтээгдэхүүн баталгаажуулалт:* Мандал сумын “Зүүн Мандал Агро” ХХК-ий “Аqua Se” цэвэр усны үйлдвэрт “Савласан ус, рашаан. Техникийн ерөнхий шаардлага MNS 5007:2007 стандарт, “Спирт бал бурам” ХХК-ий “Ауруг” цагаан архи, “Шигүдэри” нэрмэл архи зэрэг 2 нэрийн 3 бүтээгдэхүүнд “Согтууруулах ундааны техникийн зохицуулалт MNTR 1:2008, “Шимийн архи. Техникийн ерөнхий шаардлага MNS 6653:2019” стандартын шаардлагад нийцүүлэн тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олголоо.

“Спирт Бал Бурам” ХХК, “Зүүн Мандал агро” ХХК-ий бүтээгдэхүүнүүд болон иргэн П.Равдандашийн үйлдвэрлэж зах зээлд борлуулдаг тохирлын гэрчилгээтэй бүтээгдэхүүнүүдийг “Бүтээгдэхүүн баталгаажсан” тэмдэглэгээг хаяг шошгод тавих

талаар, Алтанбулаг суманд шинээр үйл ажиллагаа эхэлж буй хагас боловсруулсан махан бүтээгдэхүүний “Буянт” цехийн эзэнд бууз баншны хаяг шошгыг стандартын түвшинд хийх талаар зөвлөмж, мэдээлэл өгч ажиллалаа.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 3 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 10 нэрийн 11 стандартын борлуулалт хийж, мэдээлэл арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Баянгол, Мандал сумдын худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд “Хэмжилзүйн тухай” хуулиудын хэрэгжилтийг хангуулах үүднээс ашиглагдаж буй хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулах ажлаар 5 хоног ажилласан.

*Эзлэхүүн хэмжлийн төрлөөр:* Мандал, Баянгол сумдын 17 шатахуун түгээх газрын 53 хэмжих хэрэгсэлд, “СББ” ХХК-ий 1 спиртийн тоолуурт ээлжит баталгаажуулалт хийсэн.

*Механикийн хэмжлийн төрлөөр:* Мандал, Баянгол сумдад ажиллаж, худалдаа, үйлчилгээ, Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 83 ширхэг жинг ээлжит баталгаажуулалтад хамруулав. Мөн 4 аж ахуйн нэгжийн ургац хураалтад ашиглах 6 автопүүнд ээлжит баталгаажуулалтыг тус тус хийлээ.

*Шалган тохируулгаар:* 3 байгууллагын сорилт шинжилгээний лабораторийн 20 лабораторийн жин, 26 туухай, 2 хэмжээт саванд шалгалт тохируулгын гэрчилгээ олголоо.

*Дулаан даралтын хэмжлийн төрлөөр:* Эмнэлэг, эмийн сангийн 5 термометр, 12 цусны даралтын аппаратыг шалган баталгаажууллаа.

*Цахилгаан хэмжлийн төрлөөр:* Сүхбаатар суманд өрх, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 ба 3 фазын 16 ширхэг цахилгааныг тоолуурыг шалган ээлжит баталгаажуулалтад хамруулсан.

#### **Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Тус сард 736 баримтаар 12.8 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 08 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод байдлын самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1.</b>	<b>Орон нутгийн төсвийн нийт орлого</b>	<b>50,366,976.2</b>	<b>38,653,634.8</b>	<b>76.7</b>
<b>1.1</b>	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>33,951,937.0</b>	<b>27,171,459.8</b>	<b>80.0</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	13,843,882.8	8,896,574.0	64.3
	Сумдын төсвийн орлого	20,108,054.2	18,274,885.8	90.9
<b>1.2</b>	Сумдаас авах орлогын шилжүүлэг	2,791,332.9	1,630,502.2	58.4
<b>1.3</b>	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	7,749,845.4	5,225,241.1	67.4
<b>1.4</b>	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1,833,794.3	1,833,794.3	100.0

1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	2,059,334.5	2,059,334.5	100.0
1.6	Сум хөгжүүлэх сангийн орлого	1,798,271.4	487,044.3	27.1
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	182,460.7	246,258.6	135.0
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>50,366,976.2</b>	<b>34,541,776.4</b>	<b>68.6</b>
<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>50,366,976.2</b>	<b>34,541,776.4</b>	<b>68.6</b>
Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага		24,959,697.5	18,030,815.8	72.2
Сумдын орон нутгийн хөгжлийн сан		7,187,768.2	3,679,443.3	51.2
Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага		18,219,510.5	12,831,517.3	70.4
2.1	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	3,870,963.2	1,974,100.4	51.0
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан		3,245,950.5	2,571,523.9	79.2
Халамжийн сан		128,420.0	78,012.5	60.7
Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага		10,024,176.8	7,539,506.8	75.2
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө		950,000.0	668,373.7	70.4
<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		<b>12,755,291.6</b>	<b>12,755,291.6</b>	<b>100.0</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	5,005,446.2	5,005,446.2	100.0
Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		4,503,894.9	4,503,894.9	100.0
3.2	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	94,228.0	94,228.0	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд				
Хөрөнгө оруулалтын зардалд		4,409,666.9	4,409,666.9	100,0
Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		3,245,950.5	3,245,950.5	100,0
3.3	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	2,877,799.9	2,877,799.9	100,0
Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд		346,500.0	346,500.0	100,0
Усан хангамжийн татаас		21,650.6	21,650.6	100,0
<b>4. Тусгай сангуудын зарлага</b>		<b>1,798,271.4</b>	<b>487,044.3</b>	<b>27,1</b>
1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,798,271.4	487,044.3	27,1

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2021 - VIII	2022 – VIII	<u>2022-VIII</u> <u>2021-VIII</u>
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
1	Талх, гурил, будаа	1 650	1 600	97.0
	Гурил /Алтантараи, I зэрэг, кг/	1 300	1 500	115.4
	Талх /орон нутгийн, ш/	4 000	5 000	125.0
	Нарийн боов /кг/	2 700	3 500	129.6
	Будаа /кг/	2 400	3 300	137.5
	Элсэн чихэр /кг/			
<b>2. МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>				
	Хонины мах /кг/	8 300	9 000	108.4
	Үхрийн мах /кг/	9 800	11 000	112.2



Адууны мах /кг/	7 500	8 000	106.7
Ямааны мах /кг/	7 000	8 000	114.3
Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	5 000	166.7
Хиам /чанасан, кг/	12 500	16 500	132.0
<b>3. СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
Сүү /задгай, л/	1 200	1 200	100.0
Сүү / савласан, л/	3 200	4 500	140.6
Тараг /задгай, л/	1 300	1 800	138.5
Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	21 000	25 000	119.0
Айраг /л/	5 000		
Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	6 600	146.7
Өндөг /ш/	350	400	114.3
<b>4.БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
Ургамлын тос /л/	5 300	11 000	207.5
Өөхөн тос /кг/	2 800	3 000	107.1
Шар тос /кг/	20 000	25 000	125.1
Масло /задгай, кг/	4 700	7 500	159.6
<b>5.ХҮНСНИЙ НОГОО</b>			
Төмс /кг/	1 500	2 000	133.3
Лууван /кг/	2 400	2 500	104.2
Манжин /кг/	2 100	2 500	119.0
Байцаа /кг/	1 200	2 000	166.7
Сонгино /кг/	2 500	2 500	100.0
Өргөст хэмх /шилтэй, дарсан/	5 500	7 600	138.2
Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	4 700	5 500	117.0
<b>2. ШАТАХУУН</b>			
Бензин А - 80	2 040	2 480	121.6
Бензин А - 92	2 070	2 500	120.8
Дизелийн түлш	2 490	3 730	149.8

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Монгол Улсын хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2012-2022 он хүртэл хугацаанд хамаарах тайлан мэдээллийг гарган хүргүүлээ.

#### **Улсын бүртгэлийн хэлтэс: /иргэний бүртгэлийн талаар/**

- Төрсний бүртгэл - 144 /эрэгтэй-79, эмэгтэй-65/
- Гэрлэлтийн бүртгэл - 42
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 9
- Үрчлэлт - 2
- Эцэг тогтоолт - 14
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 7
- Нас баралт - 48
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 292
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 116
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 45
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 132
- Гадаад паспорт олголт - 2332

- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 176
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 178 тус тус бүртгэгдсэн байна.  
*/Газар өмчлөх, эзэмшиг, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар/*
- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 5374
- Анхны бүртгэл - 390
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 882
- Барьцааны гэрээ - 3813
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 117
- Лавлагаа хуулбар - 51
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо - 1361

**Цагдаагийн газар:** Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ /урьдчилсан байдлаар/

д/д	Үзүүлэлт	2021.09	2022.09	Өсөлт, бууралт	Хувь
1	Нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл	2560	3031	471	18.3 хувиар өссөн
	Үүнээс: Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл	901	1171	270	29.9 хувиар өссөн
	Үүнээс: Зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл	1659	1860	201	12.1 хувиар өссөн
2	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	497	624	127	25.5 хувиар өссөн
3	Нийт бүртгэгдсэн зөрчил	14315	24306	9991	69.7 хувиар өссөн

**Архивын тасаг:** Баруунбүрэн, Орхонтуул сумын Засаг даргын Тамгын газар, Рашаант тосгоны Захирагчийн албанд архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажлын талаар улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн.

БНШАЗК-ын гуравдугаар хурлыг хуралдуулан Сүхбаатар сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн устгах хэргийн акт, аймгийн Прокурорын газрын байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлүүдийг хэлэлцэж, баталгаажуулан хүргүүлсэн.

Сайхан сум дахь сум дундын Прокурорын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус байгууллагад ажиллаж, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар заавар зөвлөгөө өгч түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах бичгийн жагсаалт боловсруулах ажлыг гүйцэтгэн энэ талаар арга зүйг эзэмшүүлсэн.

#### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Боловсрол, соёл урлаг, спортын талаар:** 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 7 дугаар сарын 11-ний өдрийн 159 дүгээр зарлигаар Төрийн бүх байгууллага, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах ёслолтой хамтатган зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 43 цэцэрлэг сургалтын үйл ажиллагааг бүрэн эхлүүлж нийт 7154 хүүхэд суралцаж, 1111 багш, ажилтан ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 85.8 хувь, 5 настай хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 92.8 хувьтай байна. Хөгжим, бүжгийн багш 12 дутагдалтай байна.

Ерөнхий боловсролын 35 сургууль хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар бүрэн эхлүүлж, 22154 хүүхэд суралцаж, 1896 багш, ажилтан ажиллаж байна. Суурь боловсролын хамран сургалт 91.0 хувьтай байгаа бөгөөд 6 настай 2168 хүүхэд шинээр элсэн суралцаж байна.

Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/280 дугаар тушаал “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам”-ын 3 болон 4 дүгээр хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээ” /СББҮҮ/-г 2022-2023 оны хичээлийн жилд үндэсний хэмжээнд 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулж байгаатай холбогдуулан бэлтгэл ажлын хүрээнд нэгдүгээр анги даан ажиллаж буй багш болон хөгжим, биеийн тамирын хичээл ордог багш, сургуулийн удирдлагуудад онлайн сургалт, уулзалтыг 2 удаа зохион байгуулсан.

Бага ангийн сурагчдын сурлагын хоцрогдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Тоглонгоо суралцъя” үйл ажиллагааны хөтөлбөрийг Мандал сумын 4, Хэрх тосгон, Баянгол, Цагааннуур, Баруунбүрэн, Хүдэр, Сүхбаатар сумын 3 дугаар сургуульд хэрэгжүүлж, тус бүр 2,5 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлэн сургалтын материал бэлтгэх, тоглонгоо суралцах хэрэглэгдэхүүн худалдан авах боломжийг бүрдүүлэн, хичээлийн бус цагаар дугуйлан хэлбэрээр зохион байгуулж, зорилтот хүүхдүүдээ хамруулж эхлээд байна.

Хими, биологи, эрүүл мэндийн багш нарын судалгааг авахад 2022-2023 оны хичээлийн жилд химийн 39, биологийн 42, эрүүл мэндийн 53 багш ажиллаж байна.

Сургууль, цэцэрлэгт ажиллаж буй эмч нарын судалгааг гарган Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Тамхи болон электрон тамхины нөлөө” сэдэвт цахим сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн 52 эмч, 30 нийгмийн ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан.

Олон улсын Эко сургууль, цэцэрлэгийн хөтөлбөрийн анхан шатны 3 дахь сургалтад Сүхбаатар сумын МСҮТ, Алтанбулаг сумын 3-р цэцэрлэг, ахисан түвшний 3 дахь сургалтад Шаамар сумын 1-р, Алтанбулаг сумын 1-р, Мандал сумын 3, 4-р, Цагааннуур сумын 1, 2-р цэцэрлэгийн 40 багш, ажилчид хамрагдсан.

Боловсрол, шинжлэх ухааны яам болон Оросын Холбооны Улсын гэгээрлийн яам хоорондын гэрээгээр Монгол Улсад орос хэлний 12 багш ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “Арга хэмжээ зохион байгуулах тухай” А/305 дугаар тушаалын дагуу иргэдийн инновацын санаачилгыг дэмжих “МОН ИКС ПРАЙЗ” хөтөлбөрийг гэрээгээр “Стартап Монгол” ТББ зөвлөх үйлчилгээ үзүүлэх багийн бүрэлдэхүүнтэй уулзалт, сургалтыг зохион байгуулж 55 иргэн хамрагдсан.

Монголын бүх ард түмний ХҮ спортын наадамд оролцох тамирчдын сонгон шалгаруулах, анхан шатны тэмцээнийг аймгийн хэмжээнд зохион байгуулж шалгарсан тамирчид Улаанбаатар хотод зохион спортын наадамд 15 төрөлд нийт 124 тамирчид оролцож /17 медаль/ 5 алт, 6 мөнгө, 6 хүрэл медаль хүртэж 21 аймгаас багийн нийлбэр дүнгээр шагналт 6 дугаар байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн.

**Эрүүл мэндийн талаар:** Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар зохион байгуулагдаж буй “Хүн амын нас, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох үзлэг, оношилгоо”-г 2022 оны 05 дугаар сарын 01-ээс эхлэн 2 нэгдсэн эмнэлэг, 17 сум 6 тосгон, өрхийн эрүүл мэндийн төвүүдээр зохион байгуулж байна. 09

дүгээр сарын байдлаар үзлэгт 11144 иргэн хамрагдсан бөгөөд үүнээс 0-17 насны 10207 хүүхэд, 18-30 насны 405 иргэн 31-45 насны 293 иргэн, 46-60 насны 185 иргэн, 60-аас дээш 54 иргэн тус тус хамрагдсан байна.

Хүн амын нас, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох үзлэг, оношилгоог зохион байгуулах талаар сургалт сурталчилгааг цахим хэлбэрээр зохион байгуулж 3598 иргэнд хүргэсэн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 8 байгууллагыг хэлэлцэж Эрүүл мэндийн тухай хууль, аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар 5 байгууллагын үйл ажиллагааг сунгаж 3 байгууллагыг буцаасан байна.

Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийг Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдад зохион байгуулж үзлэгт нийт 481 хүн хамрагдаж, цээжний рентген зурагт өөрчлөлттэй, цэрний шинжилгээ өгөх шаардлагатай 12 хүнийг илрүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран бага насны хүүхдийн /9, 18, 36 сар/ хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг эрт илрүүлэх, хөгжлийн үнэлгээ хийх, хүүхэдтэй ажиллах талаарх арга зүйн сургалтыг зохион байгуулж 50 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 50 сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн арга зүйч багш, эмч нийт 100 гаруй албан хаагчид хамрагдсан.

**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:** Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 73538 иргэнд 47430675.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 171 иргэнд 81925.0 мянган төгрөгийг тус тус олгоод байна.

Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Сант, Цагааннуур, Сайхан, Орхонтуул, Баруунбүрэн, Хүдэр, Жавхлант, Хушаат сумд, Шаамар сумын Дулаанхан, Мандал сумын Хэрх тосгоны 28 өрхийн 75 гишүүдийн 14 бүлгийн (Мал аж ахуй 6, Хүнсний ногоо тариалах 6, Боловсруулах үйлдвэрлэл 1, Оёдол 1) төсөлд 22000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Төсөл хөтөлбөрийн хүрээнд 27 иргэнийг байнгын, 21 иргэнийг түр ажлын байраар хангаж, бүлгийн зохион байгуулалттай ажилд хамруулсан.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд баяжилт хийж ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 23 иргэн, идэвхтэй ажил хайгчаар 147 иргэн, ажил зуучлах үйлчилгээнд 62 иргэн, шинээр бий болсон ажлын байранд 85 иргэн, сул чөлөөтэй 317 ажлын байрыг бүртгэж мэдээлсэн. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр 75 иргэнд үзүүлсэн.

Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн төсөл сонгон шалгаруулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 239000.0 мянган төгрөгийг зарцуулж, 27 иргэнтэй гэрээ байгуулж санхүүжилт олгоход бэлэн болсон.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 31468009,00 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 39053966,22 мянган төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 124,11 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 18507 тэтгэвэр авагчдад 74562880 мянган төгрөгийг олгосон.

Тэтгэмжийн даатгалын сангаас 4975 даатгуулагчдад 2317076 мянган төгрөгийн ХЧТА, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгосон.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас 201 даатгуулагчид 843579 мянган төгрөгийн тэтгэвэр, ҮО-ын тэтгэмж, сувиллын зардалд олгосон байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 429 даатгуулагчдад 911186 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон.

21 аймаг 9 дүүргийн нийгмийн даатгалын 1995-2005 оны 225 лавлагааны хүсэлтийг хүлээн авч 219 лавлагааг гарган хугацаанд хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд 463 иргэд даатгуулагчаас лавлагааны хүсэлтийг авч нийт 733 лавлагааг хугацаанд гаргаж ажилласан. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь энэ сар нийт 3 удаа хуралдаж нийт 377 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 45 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ тогтоож 299 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг сунгаж 30 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

**Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:** “Хөөрхөн зүрх” ТББ-тай хамтран “Өөрийгөө хайрлахуй” эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндэд тулгуурласан сургалтыг зохион байгуулж Мандал, Ерөө, Сүхбаатар, Алтанбулаг сумын 192 эмэгтэйчүүд хамруулсан.

Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан 2 хүүхдэд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээг 1-2 удаагийн давтамжтай үзүүлсэн.

Хилийн цэргийн 0101 дугаар анги, Шүүх шинжилгээний алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчдад “Гэр бүл төлөвлөлт”, “Гэр бүлийн харилцаа” сургалт зохион байгуулж, “Сэтгэл зүйн стресс” тест авч, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж нийт 68 хүн хамруулсан.

Шүүхийн захирамжийн дагуу хүүхдийн асран хамгаалагч тогтоох шинжээчийн дүгнэлтийг 2 өрхийн 7 хүүхдэд “Шүүхийн журмаар гэр бүл цуцлахад хүүхдийн асран хамгаалагч тогтоох нэгдсэн арга зүйн гарын авлага” сэтгэл зүйн 14 багц оношилгооны тестийг авч, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж ажилласан.

Сумдын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд “Нийгмийн ажилтны мэдээллийн сан”, “Цахим бүртгэл”, “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” сэдвээр цахим уулзалт зохион байгуулж 15 сум хамрагдсан.

Залуучуудын хөгжил оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, санал санаачилгыг дэмжих, залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Сант, Орхон, Орхонтуул, Сайхан, Баруунбүрэн сумдад залуучуудын хөгжлийн 5 салбар зөвлөлийг 104 гишүүний бүрэлдэхүүнтэй шинээр байгуулсан.

Сант, Орхон, Орхонтуул, Сайхан, Баруунбүрэн сумдад Youth Vox болон явуулын үйлчилгээг үзүүлж, залуучуудад сэтгэл зүй, хууль эрх зүйн болон хөдөлмөр эрхлэлтийн талаарх зөвлөгөө мэдээллийг хүргэсэн.

“Шинэ цагийн илгээлтийн эзэд” аяны хүрээнд залуу уран бүтээлчидтэй хамтран мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг иргэд аж ахуйн нэгжид туслах, аймаг орон нутгийн залуучуудыг уриалах зорилгоор богино хэмжээний /шторк/ бичлэг бэлтгэн цахим орчинд түгээж ажилласан.

#### **Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар:** Намрын ургац хураалтад 411 комбайн, 125 будаа цэвэрлэгч, 128 будаа ачигч, 10 төмсний комбайн, 5 даршны

комбайн, 27 төмс ухагч, 32 хүнсний ногоо хураагч, 22 механикжсан үтрэм ажиллаж байна.

09 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд улаанбуудай 30.3 мянган га талбайг ангилан хадаж, 23383 га талбайгаас 30184 тн ургац хураан авч 17 хувьтай, төмс 1081 га талбайгаас 13364 тн-ыг хурааж 50,3 хувьтай, хүнсний ногоо 1395,7 га талбайгаас 15481,2 тн-ыг хурааж 48,5 хувьтай, тэжээлийн ургамал 121 га-аас 1230 тн-ыг хурааж 0,8 хувьтай, тосны ургамал 1310 га-аас 2101 тн-ыг хурааж 2,7 хувьтай байна.

11 сумын 28 аж ахуй нэгжийн 16643 га-д тариалсан улаанбуудайн талбайд сортын хянан баталгаа хийлгэх хүсэлт ирүүлснээс 25 аж ахуй нэгжийн 14737 га талбай тэнцэж, 3 аж ахуй нэгжийн 1655 га талбай бүхий улаанбуудай хянан баталгаанд тэнцээгүй байна.

“Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2022” нэгдсэн арга хэмжээ 2022 оны 09 дүгээр сарын 18-25-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, манай аймгаас 87 ногоочин, иргэд, хоршоологчид оролцож 32 нэр төрлийн хүнсний ногоо, 26 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр нийслэлийн иргэдийг хангаж нийт 204.110.000 төгрөгийн борлуулалтыг хийлээ. Уг арга хэмжээний үеэр

- Шаамар сум /Шилдэг сум/

- Зүүнбүрэн сумын иргэн Д.Болортуяа /Ил талбайн шинэ сортын хүнсний ногоо тариалж нутагшуулсан ногоочин/

- Сүхбаатар сумын иргэн Л.Чимгээ /Хамгийн олон төрлийн ногоо тарьж, сурталчилсан/

- Шаамар сумын иргэн Д.Баасансүрэн /Жимс, жимсгэнийн суулгац үржүүлэгч/

- Мандал сумын иргэн Г.Баянбямбаа /Хамгийн их төмс борлуулсан ногоочин/

- Мандал сумын “Мандал органик фүүдс” хоршоо /Шилдэг хоршоо/-гоор тус тус шалгарлаа.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 09 дүгээр сарын байдлаар 65 иргэний 87,4 сая төгрөгийн зээл төлөгдсөнөөс 8 иргэн 29 сая төгрөгийн зээл хаасан байна.

Жавхлант сумын Засаг Даргын Тамгын газар, Соёлын төв, “Бумбат таван богд” хоршооноос хамтран зохион байгуулагдсан “Цагаан эсгийний баяр-2022” наадмыг сурталчлахаар “Сэлэнгэ шүтээн” ХХК-ий сэтгүүлч Д.Туул, иргэдэд “Явуулын ахуйн үйлчилгээ” үзүүлэхээр үсчин 2, маникюр 2, гуталчин 1, “Эмма салон” 5 ажилтан, Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2 мэргэжилтэн, 2 жолоочийн хамт оролцсон.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулагддаг “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2022” нэгдсэн арга хэмжээнд 8 сумын 58 иргэн, аж ахуйн нэгжүүд 32 нэр төрлийн хүнсний ногоо, 26 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, мөн модон блок, малын тэжээлээр оролцож нийт 204.110.000 төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 5451 малчин, 4907 мал бүхий өрх, 73 аж ахуйн нэгжид 2022-2023 оны өвөл хавар 1.8 сая толгой мал, улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас бүхий газарт 93 өрхийн 52.7 мянган толгой мал өвөлжих төлөвтэй байна.

2022-2023 оны өвөл, хавар аймгийн хэмжээнд 1510 тн өвс, 710 тн тэжээлийг аймаг, сумын аюулгүйн нөөцөд, 131.0 мянган тн байгалийн хадлан, 46.5 мян.тн хүчит тэжээл, 5824 тн эрдэс тэжээл бэлтгэхээс 09 дүгээр сарын байдлаар малчин болон мал бүхий иргэдийн түвшинд 65.6 мян.тн байгалийн хадлан бэлтгэсэн мэдээтэй байна. Хадлан бэлтгэл 50 хувьтай явагдаж байна.

Бизнесийн зориулалтаар 8 суманд 7000 мян.тн хадлан бэлтгэн борлуулж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Малын гений санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх хөдөлгөөнийг өрнүүлэх тухай” 2021 оны А/108 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын А/243 тоот захирамжаар 17 сумын малчин, мал бүхий өрх, фермерүүдийн нийт 4700 үхэр сүрэгт зохиомол хээлтүүлгийн ажлыг Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлээд байна.

Малын удмын сангийн үндэсний төвийн 12 гэрээт техникч сумдад хуваарилагдан махны чиглэлийн 2702, сүүний чиглэлийн 1998 үнээнд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийхээс 2455 үнээнд зохиомол хээлтүүлэг хийгээд байгаа нь хээлтүүлэг хийвэл зохих үхэр сүргийн 25.4 хувьд хээлтүүлэг хийгээд байна. Орхонтуул, Сант, Орхон, Түшиг, Жавхлант сумдад зохиомол хээлтүүлгийн ажил хийгдэж дууссан. Бусад сумдад үхэр сүргийн зохиомол хээлтүүлгийн ажил үргэлжилж байна. Аймгийн хэмжээнд үхэр сүрэгт хийгдэж буй зохиомол хээлтүүлгийн ажил 70 хувьтай явж байна.

**Мал эмнэлгийн үйлчилгээний талаар:** Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны “Судалгаа авах тухай” 01/917 тоот албан даалгавар, удирдамжийн хүрээнд сумд дахь МЭТ-ийн мэргэжилтнүүд 4 удаагийн давтамжтай үхрийн арьс товруутах өвчний идэвхгүй тандалт судалгаа зохион байгуулсан.

Мал эмнэлгийн газрын төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлж гүйцэтгэлийг мал эмнэлгийн нэгдсэн системд оруулан ажиллаж байна. Гүйцэтгэлийн үр дүн:

- Галзуу өвчний дархлаажуулалтад 48000 толгой мал, амьтан хамрагдахаас 47998 толгой мал, амьтан буюу 99,9 хувь
- Гахайн мялзан өвчний дархлаажуулалтад 12000 толгой гахай хамрагдахаас 11998 толгой гахай буюу 99.9 хувь
- Бруцеллёз өвчний дархлаажуулалтад 432000 төл мал хамрагдахаас 426540 төл мал буюу 98.7хувь
- Адууны томуугийн дархлаажуулалтад 32000 толгой мал хамрагдахаас 25120 толгой мал буюу 78,5 хувийн тус тус гүйцэтгэлтэй технологит хугацаанд хамруулж үйлчилгээний хөлс, бусад зардлыг тооцож төсвөөс санхүүжүүлсэн.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад нийт 32300 толгой мал, амьтныг хамруулахаар төлөвлөснөөс Мал эмнэлгийн газрын нөөц вакцинаар 09 дүгээр сарын 15-ны өдрөөс Баянгол, Жавхлант, Сайхан, Шаамар сумын нийт 68800 толгой мал, амьтныг дархлаажуулах ажлыг эхэлсэн.

- Угаалгад 1667100 толгой мал хамрагдаж 104.6 хувь гүйцэтгэлтэй хэрэгжсэн.

Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, гарал үүсэл нь тодорхой, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд 09 дүгээр сарын байдлаар хүнсэнд мал эмнэлгийн гарал үүслийн 703 гэрчилгээгээр адуу 66, үхэр 394, хонь 2297, ямаа 590, гахай-6 толгой буюу нийт 3353 толгой мал амьтан, мах, махан бүтээгдэхүүн 109.955 кг, сүү, сүүн бүтээгдэхүүн 465.586 кг, арьс шир 2 ширхэг нийлүүлсэн.

09 дүгээр сарын байдлаар мал эмнэлгийн гарал үүслийн 30 гэрчилгээгээр нийт 1034 толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийгдсэн. Үүнээс өөр аймаг, сумаас нийт 328 толгой /отор нүүдэл- 279, үржилд-49/ мал, амьтан, аймгаас өөр аймаг, сум руу нийт 686 толгой /отор нүүдэл- 547, үржилд-139/ мал, амьтан, сум хооронд 20 толгой мал амьтан үржлийн зорилгоор шилжилт хөдөлгөөн хийгдсэн.

Гарал үүслийн гэрчилгээгүй мал оруулж ирсэн малчинд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож 150.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ, 3 сумын улсын байцаагч 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж арилгуулах арга хэмжээ авсан.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдаалж байгаа мах махан бүтээгдэхүүний 2760 кг үхрийн махны 23 дээж, 428 кг хонины махны 68 дээж, 260 кг ямааны махны 13 дээж, сүү, сүүн бүтээгдэхүүний 120 л сүү, ааруул, тараг, цөцгийнний 17 дээж, зөгийн балын 2 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг хийсэн.

Сайхан, Орхон, Орхонтуул, Зүүнбүрэн, Алтанбулаг сумдаас болон импортоор орж ирсэн нийт 590 дээжид ийлдэс судлалын шинжилгээ, Алтанбулаг, Сант сумдаас ирсэн 39 эмгэгт дээжид нян судлалын шинжилгээг хийж хариуг мал эмнэлгийн газрын дарга, ерөнхий эмчээр баталгаажуулан малчин, мал бүхий иргэдэд хүргүүлж цахим системд бүртгэсэн.

**Байгаль орчин, Ус, цаг уурын талаар:** Аймгийн хэмжээнд 6 сумын 96 иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулаад байна .

2022 оны намрын тооллогын дүнгээр 45 төрлийн 5-60 см өндөртэй **19,393,796** ширхэг тарьц , 0.4-2 м өндөртэй **2.626.007** ширхэг суулгац, 0,3-1,6м өндөртэй **2,075,386** ширхэг мөчрийг тус тус тариалсан.

Зах зээлд борлуулах тарьц суулгацын мэдээ: Орон нутгийн зах зээлд гаргахаар нийт 57 иргэн, нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагын 0-3 настай **4,430,314** ширхэг тарьцыг 100-5,000 төгрөгийн хооронд, 6-25 настай **1,292,334** ширхэг суулгацыг 20,000-250,000 төгрөгөөр худалдаанд гаргахаар бэлтгэсэн.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын газартай хамтран Ерөө суманд үйл ажиллагаа эрхэлдэг уул, уурхайн компаниудад хяналт, шалгалт зохион байгуулж, усны орлогод 80,0 сая төгрөг төвлөрүүлсэн.

Аймгийн Засаг даргын А/279 дугаар захирамжийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын Газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон бусад хууль хяналтын байгууллагуудтай хамтран Ерөө сумын нутаг дэвсгэрт 5 хоногийн хугацаанд хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:** Сумдын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан газар эзэмших эрхийн дуудлага худалдаанаас Сүхбаатар суманд 4 нэгж талбар, Алтанбулаг суманд 3 нэгж талбар, шинээр 10 нэгж талбар, Баруунбүрэн суманд 1 нэгж талбар, Сант суманд 8 нэгж талбар, Жавхлант суманд 9 нэгж талбар, Мандал суманд 19 нэгж талбарын дуудлага худалдааг газрын цахим биржид байршуулж “Зууны мэдээ” сонинд зар өгч дуудлага худалдаанд оролцож буй иргэнд утсаар зөвлөгөө өгч ажилласан.

e-reporting.eitimongolia.mn сайтаас аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 201 ашигт малтмалын А болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн мэдээллийг авч газрын мэдээллийн санд газар эзэмших, ашиглах эрх нь үүссэн ашигт малтмалын 75 нэгж талбарын газрын төлбөрийн судалгааг гаргаж ажилласан.

9 сумын 54 нэгж талбарын зах зээлийн үнийн мэдээг цуглуулж газрын биржийн цахим системд 7 сумын 43 үнийн мэдээг бүртгэж Шаамар, Хушаат, Сүхбаатар сумын иргэдэд зах зээлийн үнийн мэдээний талаар мэдээлэл өгч ажилласан.



Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг 17 суманд, аймгийн хэмжээнд 98 бэлчээрийн фотомониторингийн цэгт хэмжилт хийж ажиллалаа.

Дараах барилгуудад үзлэг хийж ажиллалаа. Үүнд:

- Мандал сумын “Бороо Гоулд” ХХК-ий захиалгаар хийлгэж буй Зүүн сангийн хаягдлын усан сангийн байгууламжийг “Усны барилга” ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажилд захиалагчийн хүсэлтийн дагуу хяналт хийхэд суурь нягтруулга хийгдсэн мембран дэвсэх ажил 70 хувьтай, борооны улмаас ажил удааширсан байв.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Алтанбулаг суманд хийгдэж буй бохир усны шугамын ажил “Сумыг хилийн боомтын цэвэрлэх байгууламжтай холбох бохир ус зайлуулах шугам”-д захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллав. Ажлын гүйцэтгэгчээр “Нягт холбоос” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэж байна. Барилгын талбайд ашиглагдах материал эдлэхүүн буусан. БУХ-29 худгаас БУХ-32 дагуух угсралтын ажил хийгдэж дууссан. БУХ 29- өөс дээш БУХ-26 хүртэл ажил үргэлжилж байна. Ажлын явцад /БУХ-29/-/БУХ-32/ худгуудын шугамын ёроолын гүн 1,5 м байгаа учир энэ хооронд шороон овоолгыг нэмж худгийн хүзүүвчийг өндөрлөх шаардлагатай талаар зөвлөмжийг өгч ажилласан.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мандал суманд бохир усны шугам татах ажлыг “Цагаан зуун” ХХК гүйцэтгэж байна. Ажлын зургийн 2-р хэсэг буюу Эмнэлгийн арын төв гудамж, түүний уулзвараас дээш хэсгийн 730-д метр шугам угсралтын ажил хийгдэж дууссан байна. Хийгдсэн ажил хэмжилт шалгалтыг хийж үзэхэд зургийн дагуу угсралтын ажлыг гүйцэтгэсэн байна. /БУХ-2-31/ -ээс дооших шугам угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Ажлын явцад дараах зөвлөмжийг өгч ажилласан. 2-р хэсгийн ажлын ил далд ажлын актыг бичиж баталгаажуулах, худгуудын улыг цэвэрлэж дулаалгатай модон таг тавих, 10 см элсэн дэвсгэрийг тавьж ажлыг гүйцэтгэх.
- Баянгол суманд баригдаж буй “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллав. Барилгын салхивчийн ажил, цонх суулгах ажил, гадна зам талбайн тэгшилгээний ажил хийгдэж байна. Гадна зам талбайн түвшний өндөржилтийг дахин намсгаж цоклын төвшнийг өндөрсгөх шаардлагатай.
- Алтанбулаг суманд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Хяраан голын гүүр”-ийн ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллав. Захын бетон тулгуурыг цутгах ажил дууссан. Металл дам нуруу угсрах ажил хийгдсэн. Голын голдирол засах ажил хийгдэж байна.

### **Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

#### **Алтанбулаг сум:**

Аймгийн Засаг даргын 2022 оны “Бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулах тухай” А/396 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган Долоон даваа, Хуурай нуур, Борын жалга, Хонд самбар зэрэг нийт 850 га талбайг цэвэрлэж 30 тонн хогийг сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн төвлөрүүллээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын санаачилгаар БНСУ-ын Сөүл хотын Үньпён мужийн Засаг дарга болон аймгийн Засаг дарга хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагааны үед зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд Алтанбулаг сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг 6 иргэн оролцсон.

Сумын хэмжээнд ургац хураалтын ажил эхэлж 09 дүгээр сарын байдлаар улаанбуудай ангилан хураасан 200 га, шууд хураасан 282 га, цайруулсан 50 га нийт 330 тонн, Овьёос ангилан хадсан 120 га, шууд хураасан 80 га нийт 64 тонн, Гурвалжин будаа 50 га-аас 25 тонн, Тосны ургамал 700 га ангилж, 210 га цайруулан 84 тонн ургац, төмс 43 га-аас 430 тонн хүнсний ногоо 32,30 га-аас 338 тонн тус тус хураагаад байна

Хадлангийн талбайн газар ашиглуулах гэрээг 128 иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулж 3251 тонн хадлан тэжээл бэлтгээд байна.

#### **Баруунбүрэн сум:**

Сумын хэмжээнд ургацын урьдчилсан балансыг тогтоож ажилласнаар улаанбуудайн дундаж ургац 12 цн-ээр тогтоогдсон. 09 дүгээр сарын байдлаар 3 аж ахуй нэгж ургац хураалтад орж 200 га талбайгаас 280 тонн улаанбуудай хураан авсан.

Төмс, хүнсний ногооны хувьд хүнсний ногоо 44,85 га талбайгаас 272,2 тонн, төмс 40 га талбайгаас 240 тонн ургац, 8500 тонн хадлан бэлтгээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах, их хааны үйл хэргийг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулж, 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 20 бүлэгт 521 суралцагч, 52 багш, ажилчидтайгаар сургалт хүмүүжлийн ажлаа эхлүүлээд байна.

2022-2023 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 6 бүлэгт 158 хүүхэд, 25 багш, ажилчидтайгаар сургалт хүмүүжлийн ажлаа эхлүүлээд байна.

Сумын хэмжээнд 9 дүгээр сард тоон гарын үсгийг 20 иргэнд, өссөн дүнгээр 222 олгоод байна.

Сумын Эрүүл мэндийн төвөөс хөдөөгийн 1,2-р багийн айл өрхүүдээр идэвхтэй үзлэг зохион байгуулж, хичээл сургалтын үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн 50 сурагчдад томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулж, витаминжууллаа.

#### **Баянгол сум:**

Хууль, зүй дотоод хэргийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Авлигатай тэмцэх газрын даргын 2022 оны “Хамтарсан зөвлөмж”, Боловсролын Ерөнхий газрын 2022 оны 1/1449 тоот албан бичгийн дагуу 2022-2023 оны хичээлийн жилд шинээр элсэн орж буй сурагчдын бүртгэлийг нээлттэй ил тод зохион байгуулж, хамран сургах тойргийн 83,8 хувийг хамрууллаа.

Боловсролын чанарын шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны 09 сарын 13-нд Дархан-Уул аймгийн Засаг даргын боловсрол, шинжлэх ухааны бодлогын зөвлөх, профессор багш Р.Батжаргал “Харилцаан дахь бидний ялгаатай байдал” сэдвээр ажлын байран дээр сургалт ярилцлага зохион байгуулж 20 багш ажилтан, мөн “Монгол өрх” сэтгэлзүйн хүрээлэнгийн захирал С.Баасанбатаар ахлуулсан сэтгэл судлаач багш нар “MON EQ” мэргэжил сонголтын аяны хүрээнд сурагчдын сонирхол, авьяас билгийг илрүүлж мэргэжлээ зөв сонгоход нь чиг баримжаа олгох, зөвлөн туслах зорилгоор мэргэжил сонголтын багц оношилгоо хийж, зөвлөгөө өгөх үйлчилгээг тус тус зохион байгуулж нийт 16 эцэг эх, 145 сурагч, 4 багш, тус тус хамрагдлаа.

Соёлын яамнаас зохион байгуулж буй “Соёлын орон зай” арга хэмжээний хүрээнд түүх соёлоо сурталчлан таниулах зорилгоор “Орон нутгаа судалцгаая” аян, хүүхдийн ном зохиолыг сурталчлах “Номын ертөнцөөр аялцгаая” үзэсгэлэнг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор Ерөнхий боловсролын сургуулийн 37 бүлгийн 1200 хүүхэд хамрагдлаа.

Сумын Засаг даргын Тамгын өвөлжилтийн бэлтгэл хангах, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх арга хэмжээг зохион байгуулж 09 дүгээр сарын байдлаар Хараа баг 2579 га 128, Баян баг 2833,5 га талбайд багийн 136 иргэнд Шарын голын 35 иргэнд Гонир баг 1417,8 га 98 иргэнд байгалийн ургамлыг хадлангийн зориулалтаар ашиглах эрхийн бичгийг өгч, 130800942 тоот дансанд 8,397,250 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

#### **Ерөө сум:**

Аймгийн Засаг даргын “Өвөлжилтийн бэлэн байдлыг хангах тухай” 2022 оны 02 дугаар албан даалгавар, сумын Засаг даргын захирамжийн хүрээнд 1,2,3-р багийн 239 малчин, мал бүхий иргэн 3038 га, бизнесийн зориулалтаар 12 иргэн 650 га талбайд өрхийн хэрэгцээнд 8920 тн, бизнесийн чиглэлээр 200 тн өвс бэлтгэхээр гэрээ хийгдсэн ба одоогийн байдлаар 84 хувьтай явж байна. Мөн өвс, тэжээлийн фондод 60 тн өвс, 30 тн тэжээлийг бүрдүүлээд байна.

2022 оны 09 дүгээр сарын байдлаар намрын ургац хураалт явц 12975 га-аас үр тариа хураахаас улаанбуудай 5707 га-аас 5606 тн, малын тэжээл 500 га-аас 500 тн, рапс 650 га-аас 325 тн хураан аваад байна. Төмс 20 га-аас 260,4 тн, хүнсний ногоо 59,6 га-аас 611,2 тн хураан аваад байгаа бөгөөд ургац хураалтын явц 50 хувьтай байна.

Мал эмнэлгийн Ерөнхий газрын 2022 оны А/166 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/329 дүгээр захирамж, сумын Засаг даргын А/152 дугаар захирамжийн хүрээнд 269 малчин мал бүхий өрхийн 3600 тугал, 176 өрхийн 17000 толгой бог мал Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан байна.

Мөн Бруцеллэз өвчний тандалтын зорилгоор давхардсан тоогоор 88 өрхийн 182 толгой хуц ухна 10 өрхийн 10 бух, 120 үнээнээс цусны дээж авч аймгийн лабораторийн шинжилгээнд явууллаа.

Мал эмнэлгийн Ерөнхий газрын 01/843, 01/917 тоот удирдамжийн дагуу 3 удаагийн давтамжтай 60 өрхөөс утсаар Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлээгийн идэвхгүй тандалтыг авч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/197 дугаар захирамж, сумын Засаг даргын 2022 оны А/52 дугаар захирамжаар Томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 41 өрхийн 1800 толгой адуу хамруулсан байна.

#### **Жавхлант сум:**

Сумын Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 13 тоот албан даалгаврын хэрэгжилтийг явцтай танилцах өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг төр төсвийн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл, сургууль цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн бэлэн байдлыг шалгаж, заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ний өдрийн “Бүх нийтээр хог цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А/376 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж сумын төвд бүх нийтийн цэвэрлэгээ, шарилж устгах, ногоон байгууламжид засал хийх ажлыг зохион байгууллаа.

Тус захирамжийн хүрээнд сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбай болон айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын ойр орчмын 6.5 га талбайн хог хаягдлыг нийт 65 төрийн албан хаагчид, иргэд 24 нийт 89 хүн цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хаяж зайлуулах, төр төсвийн байгууллагын ногоон байгууламжийн хог ургамал, шарилжийг түүж цэвэрлэх, ногоон байгууламжийн нийт 250 гаруй мод буцыг засал хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Сумын орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын төвлөрсөн хогийн цэгийн хашаажуулах тендерт шалгарсан Жавхлант сумын Баянжаргалан Хайрхан ХХК хогийг цэгийг хашаажуулах ажил хийгдэж дууслаа.

Сумын иргэдийн эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангах, мал амьтнаас хүнд халдварладаг өвчин, бусдад гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор золбин нохойнуудыг устгах мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгууллаа.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хатуу хучилттай автозамын ажлын тендер худалдан авах ажиллагааны цахим системд зарлагдаж Улаанбаатар хотын “Монгол туургатны зам” ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан зам засварын ажлаа эхлүүлээд байна.

### **Зүүнбүрэн сум:**

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор тус суманд ажиллаж улсын төсвийн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Хүлэмжийн аж ахуй” төслийн явцтай танилцаж, аймгийн Засаг даргаас томилсон ажлын хэсэгт “Хүлэмжийн аж ахуй”-н паркийг хүлээлгэн өглөө.

Аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгавар, сумын Засаг даргын А/143 тоот Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 13 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн “Илдэн бүрэн” ОНӨААТҮГ байгуулагдаж уурын зуух, халаалтын үйл ажиллагааг хариуцан төр төсвийн байгууллагын халаалтыг өгч эхлээд байна.

Сумын хэмжээнд 09 сарын байдлаар 5619 га талбайгаас 7550 тн буудай, 1081 га тайлбайгаас 380 тн рапс, 261,35 га талбайгаас 1492,8 тн төмс, хүнсний ногоо хурааж, 8000 тн байгалийн хадлан тус тус бэлтгэлээ.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулж буй “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээнд оролцсон ногоочдоос Бэлчир 2 дугаар багийн иргэн Д.Болортуяа “Ил талбайд хүнсний ногоо тариалж нутагшуулсан номинаци”-д шалгарлаа.

Сумын Засаг даргын А/172 тоот захирамжаар “Эрүүл мэнд ба ундны ус” аяныг 2022 оны 09 дүгээр сараас эхлэн 1 жилийн хугацаатай зохион байгуулахаар баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль 30 багш, 544 хүүхэд, сургуулийн өмнөх боловсролд 23 багш, 195 хүүхэд тус тус хамрагдаж байна.

Соёлын өвийн үл хөдлөх биет, сүмийн туурийн улсын тооллого орон нутагт зохион байгуулагдан 184 биет өв, 2 сүмийн туурийг тоолуулж цахим бүртгэлд хамрууллаа.

Сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж нийт 120 хүн хамрагдлаа.

Хүн амыг зооноз өвчний эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд нийт 290 өрхийн 20600 толгой төл малыг хамрууллаа.

### **Мандал сум:**

Сумын Засаг даргын 2022 оны “Удирдах ажилтны мэдээллийн цаг” арга хэмжээний хэрэгжилтийг ханган төр, төсвийн байгууллагын удирдлагууд гэмт хэргийн нөхцөл байдал, халаалт дулаан, цэвэр бохир ус, татвар, ойн дагалт баялагийн талаар нийт 36 удирдах албан тушаалтанд мэдээлэл хийлээ. Салбарын мэдээллийг бусдадаа хүргэх, нэгдсэн мэдээллээр хангалаа.

Сумын Засаг даргын 2022 оны А/295 тоот захирамжаар сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй боловсролын 16 байгууллагад “2022-2023 оны хичээлийн

жилийн бэлтгэл бэлэн байдал"-ыг хянаж, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, шийдвэрлэж, ажилласан.

Азийн хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сангийн хамтарсан санхүүжилттэй, Иргэний нийгмийн 26 байгууллагаас сумын Засаг даргатай байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжиж буй "Ковид-19 цар тахлын нөлөөг олон нийтийн оролцоотой бууруулах нь" төслийн хяналтын үнэлгээний ажлын хэсэг ирж төслийн үр шим хүртэгчидтэй уулзаж, үр дүнтэй танилцлаа.

Баян-Арцат 9 дүгээр баг "Дэлхийн Зөн Зүүнхараа" орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран Хосын тогтвортой харилцааг дэмжих зорилго бүхий "Миний гэр бүлийн баяр хөөр" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 18-45 насны 40 иргэнийг хамруулж мэргэжлийн сэтгэл зүйч багш нарын зөвлөгөө өгч ажиллалаа.

Оросын холбооны Эрхүү хотноо зохион байгуулагдсан "Байкалпро" Олон Улсын Жюүжицүгийн тэмцээнд 6 орны 660 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс тус сумын спорт сургалтын цогцолборын арга зүйч н.Баяр-Эрдэнэ өөрийн шавь Б.Хулан, С.Сэлэнгэ, О.Мөнх-Учрал нарыг бэлтгэн оролцуулж 2 алт, 1 мөнгөн медаль хүртлээ.

Сумын Засаг даргын Тамгын газар "Дэлхийн зөн Зүүнхараа" ОНХХ-тэй хамтран зорилтот бүлгийн 3 өрхөд иж бүрэн 5 ханатай гэрийн тусламжийг үзүүллээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/372 тоот тушаалаар хуш модны самар бэлтгэх дээд хэмжээг ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар нийлээд 1395 тн, Хан Хэнтий Улсын тусгай хамгаалалттай газарт ахуйн зориулалтаар 3039 тн самрын зөвшөөрөл тус тус батлагдаж ирсэн. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр санал хүргүүлсэн.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 41 дугаар тогтоолоор 188 га талбайд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийхээр хуваарилсан. Өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийх хуваарийн дагуу 2022 оны намар 18 аж ахуй нэгж байгууллагуудын 140,8 га талбайг хүлээн авлаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх өдрийг угтан тэдний үр хүүхдүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулж, 19 өрхөд түлээний мод олголоо.

Аймгийн Засаг даргын 2022 оны "2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд сумын **271** иргэнд 1462 м3 түлээний гоожин олгосон цаашид 386 м3 гоожин олгох боломжтой. Мөн түүнчлэн 36 аж ахуй нэгж байгууллагууд 10789 м3 түлшний мод бэлтгэхээс 255 м3 бэлтгэлээ. Ойн анги гэрээгээр эзэмшигч 35 мэргэжлийн байгууллагуудад үүрэг чиглэл өгсний дагуу 6 ойн мэргэжлийн байгууллагууд 279,6 м3 түлшний модыг татан төвлөрүүлээ. 4 нөхөрлөл, 5 аж ахуйн нэгжид 787 м3 хэрэглээ, 356 м3 түлээ, 3 нөхөрлөл, 6 аж ахуй нэгж байгууллагын эзэмшлийн ойн сангаас 48 иргэнд 486 м3 түлээний мод бэлтгэх эрхийн бичгийг тус тус олгож 9.9 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. Мод бэлтгэх эрхийн бичгийг үндэслэн хэрэглээний 1225,55 м3, түлээний 127 м3 нийт 1352,55 м3 модыг 80 гарал үүслийн гэрчилгээгээр олгосон.

Малчин, мал бүхий иргэдийн өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, хадлан тэжээл бэлтгэлийн ажлыг хангах ажлын хүрээнд 364 малчин, мал бүхий өрх, 4 аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан сумын аюулгүй нөөцөд 1100 боодол өвс нөөцөллөө. Мөн 36 иргэн, аж ахуй нэгж байгууллага 5233,3 га-д үр тариа, улаанбуудай

5146,3 га талбайд улаан буудай, 87 га талбайд бусад үр тариа, 1126 га талбайд техникийн ургамал, тэжээлийн ургамал 282 га талбайд тариалж ургац хураан авахад бэлтгэж байна.

### **Орхон сум:**

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль эрх зүйн сургалт сурталчилгааг зохион байгуулах ажлын хүрээнд “Авлигатай тэмцэх тухай хууль”, “Газрын тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн таниулга сурталчилгааг зохион байгуулж, 211 өрхийг хамруулан явуулын сурталчилгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сумын хэмжээнд 09 дүгээр сард коронавируст халдвар (Ковид-19)-ын 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ, сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 24 сарын хугацаанд 30 өрхийг сонгон авч өрхийн орлогоо нэмэгдүүлэх, бизнес эрхлэх ур чадварын сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, бизнес эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэгийг үзүүлсэн. Энэ ажлын “Үр дүнгийн баяр”-аа тэмдэглэж, үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа.

Уг ажлын хүрээнд дараах хөрөнгө оруулалтын ажил хийгдлээ. Үүнд:

- Тугалтай бяруутай үхэр- 9 өрх
- Оёдлын машин-2 өрх
- Хүлэмж-5 өрх
- Өндөг дарагч, тахиа-3 өрх
- Гахай аж ахуй эрхлэх-3 өрх
- Тахианы аж ахуй-3 өрх
- Ааруул хатаагч-3 өрх
- Мужааны тоног төхөөрөмж-1 өрх
- Гар утас засвар-1 өрх
- Баганан тулгуур гутлын машин-2 өрх
- Дугуй засвар-1 өрхөд /нийт санхүүжилт 59.983,000/ олгосон байна. Мөн Гэр бүлийн туршилтын хөтөлбөрт шинээр хамрагдах 9 өрхөд 50 литрийн багтаамжтай цэвэр усны сав олголоо.

Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, тогтоомжийг сурталчлах, хүчирхийллийн нөхцөл байдал, эрсдэлтэй гэр бүл, иргэд /энэ төрлийн нуугдмал гэмт хэрэг/-ийг илрүүлэх зорилгоор Бэлэндалай багийн 201 өрхийн судалгааг холбогдох чиглэлээр гарган, тандалт хийж ажиллалаа.

Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрээс хориотой үед зөвшөөрөлгүй хуш модны самар түүж бэлтгэсэн Орхон аймгийн харьяат 1 иргэн, Дархан-Уул аймгийн харьяат 1 иргэнд тус бүр 300.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, 685 кг самрыг хурааж улсын орлого болгон Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өглөө.

Тус сумын 2-р багийн Мангирт гэх газарт эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газар ашигласан 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 500.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцсон байна.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйг газраас гаргасан малын тэжээлийн хадлан бэлтгэх төлөвлөгөөгөөр сумын хэмжээнд 7042 тн хадлан бэлтгэхээр тусгагдсан, одоогийн байдлаар 4100 тн өвс бэлтгээд байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 58.2 хувьтай байна.

Хүнс Хөдөө Аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг дэмжих төсөл, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран хэрэгжүүлж

байгаа нутгийн үүлдрийн хонийг Франц улсын махны чиглэлийн “Меринос” үүлдрийн хоньтой хэрэгцээний эрлийзжүүлэг явуулах арга хэмжээнд хамрагдсан 2 өрхийн эрлийз хурганд үзлэг хийх, амьдын жингийн урьдчилсан жигнэлтийг явуулах ажлыг зохион байгуулж, нутгийн болон эрлийз 40 тоо толгой хургыг хамрууллаа.

Сумын Засаг даргын 2022 оны “Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, дархлаажуулалтын зохион байгуулах тухай” А/92 тоот захирамжийн дагуу “Бүрэн-Орхон” ХХК нь 81 өрхийн 1200 тугал, 65 өрхийн 10600 хурга ишиг, “Эгдэм” БГБХН нь 72 өрхийн 800 тугал, 78 өрхийн 12000 хурга ишгийг вакцинд хамрууллаа.

Мал амьтны халдварт шимэгч өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд хонь 13954, ямаа 11187 нийт 25141 толгой бог малыг угаалгад хамруулаад байна.

Цагдаагийн байр болон сумын төвийн 6 дугаар хэсгийн айлуудад халаалтын шугам тавих 120.000,000 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг “ЭЛ СИ БИ” ХХК гүйцэтгэж 50 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

“Монгол туургатны зам” ХХК-тай 50.000,000 төгрөгийн гэрээ байгуулан Бэлэндалай багийн 42-р зөрлөгийн зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлгийн ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын явц 90 хувьтай байна.

#### **Орхонтуул сум:**

Сумын Засаг даргын захирамжаар өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах ажлын хэсэг гарган иргэдэд цахимаар болон газар дээр нь очиж мэдээлэл хүргэн ажиллаж байна.

2022-2023 оны хичээлийн жилд Сургуулийн өмнөх боловсролд 180 хүүхэд, 29 багш ажилчид, ерөнхийн боловсролын сургуульд 1-р ангид I сургуульд 18, II сургуульд 28 хүүхэд элсэн суралцаж нийт 582 хүүхэд, үүнээс дотуур байранд 43 сурагч, 71 багш ажилчид үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Сумын Засаг даргын 2022 оны “Сурагчдын цүнхний жингийн стандарт мөрдүүлэх тухай” захирамжийн дагуу 1-12-р ангийн ерөнхий боловсролын сургуультай хамтран сурагчдын цүнхний жинг хэмжих ажлыг зохион байгууллаа.

Улаанбаатар хотын “Монгол ВИ.И.ТИ НЕТ” ТББ-ын хамт олон “Хайрын бэлэг” төсөлдөө хамруулан зорилтот бүлгийн 3 айл өрхөд 7 бог мал бэлэглэлээ.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Рашаант тосгонд Хүнсний ногооны зоорь, Баянцогт 2-р багт Мал угаалгын ванн барих, Малын эрүүл мэндийг хамгаалах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малчдад хийх сургалт сурталчилгааны тоног төхөөрөмж худалдан авах ажлууд 100 хувьтай хийгдэж дууссан.

Сумын хэмжээнд ургац хураалт 09 дүгээр сарын байдлаар улаанбуудай 3658 га-аас 4921 тн хураан авч 36.5 хувьтай, тосны ургамал 630 га-аас 605 тн хураан авч 10.6 хувьтай, төмс 38 га 304 тн, хүнсний ногоо 64.5 га-аас 558 тн ургац хураан авч хураан авалт 47 хувьтай явагдаж байна. Нийт 71 иргэн бизнесийн зориулалтаар 10.000 га талбайгаас 4127 тн байгалийн хадлан бэлтгэсэн байна.

#### **Сайхан сум:**

Аймгийн Засаг даргын 2022 оны А/376 дугаар захирамжийн хүрээнд Сайхан сумын хэмжээнд бүх төр төсвийн байгууллагуудтай хамтран бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж хог хаягдал болон ногоон байгууламжийн зэрлэг ургамал, шарилжийг устгаж, хаягдал ургамлыг ачуулан эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн ажилласан.

Улс, аймаг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дараах ажил үйлчилгээг хийж байна. Үүнд:

1. Сайхан суманд хийгдэж буй Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 150.000.000 төгрөгийн гэр хороолол, Номгон тосгоны камержуулалтын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй хийгдлээ. Үүнд: Хөтөл хотод 41 шон гэрэлтүүлэг, 3 камер Номгон тосгонд 20 шон гэрэлтүүлэг, 2 камер суурилуулах ажлыг “Сонголт нар” ХХК гүйцэтгэж Улсын комисс болох аймгийн Мэргэжлийн хяналтын газар, барилга хот байгуулалтын хэлтэс, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нар ажиллаж ашиглалтад хүлээн авлаа.
2. 2021 онд дуусаагүй “Бичил хорооллын дунд хийгдэж буй ногоон байгууламж, тохижилт, авто зогсоол шинээр хийх, стандартад нийцсэн хогийн савтай болох” ажлыг “Мөнх Од Цацрал” ХХК гүйцэтгэж дууссан.
3. “Сайхан Төгөл” ХХК 49.029.000 сая төгрөгийн гадна талбай автозогсоол нэмж хийх засварын ажлыг 50 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.
4. “Хөтөл цэнэг” ХХК 20.0 сая төгрөгийн Хүүхдийн тоглоомын талбай шинэчлэх, талбайн гэрэлтүүлэг шинээр хийх ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн Овоот хорооллын Хүүхдийн тоглоомын талбай, цамхаг гэрэлтүүлэг хийгдэж байна.

Сайхан болон Баруунбүрэн сумдын Засаг дарга нарын 2022 онд байгуулсан Мод бэлтгэх гэрээний дагуу өвөлжилтийн бэлтгэл ханган Сайхан сумын хэмжээнд 09 дүгээр сарын байдлаар 130 иргэн 444 м3 түлээ бэлтгэн аваад байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/379, сумын Засаг даргын 2022 оны А/171 дүгээр захирамжийн дагуу тус сумын “Хөх сэрхийн өвөр” ББН, “Цөм сүрэг” МЭҮН бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сумын хэмжээнд 280 орчим өвөлжөөний газар байгаагаас гэрчилгээ авсан нь 130 малчин байна.

Сайхан сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэс, сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран “Осол гэмтлээс урьдчилан сэргийлье” дадлага өдөрлөгийг зохион байгууллаа.

#### **Сант сум:**

Сумын хэмжээнд ургац хураалтын мэдээгээр үр тариа 586 га талбайд ангилан хадалт хийж үүнээс 500 га талбайг цайруулж 500 тн ургац, тосны ургамал 168 га талбай ангилан хадалт, төмс 68 га талбайгаас 748 тн, хүнсний ногоо 86 га талбайгаас 806,6 тн ургац тус тус хураан авсан. Ургац хураалтын ажил үр тариа 31,8 хувь, төмс 52 хувь, хүнсний ногоо 37 хувьтай явагдаж байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 2110 га газарт 148 иргэн, 1 аж ахуйн нэгж, байгууллагатай хадлан бэлтгэх гэрээ байгуулсан. 9 дүгээр сарын 22-ний өдрийн байдлаар сумын хэмжээнд бүдүүн өвс 3712 тн, үйлдвэрийн тэжээл 35 тн, давс, хужир, шүү 25,6 тн бэлтгээд байна. Бизнес хадлангийн зориулалтаар 10 иргэн, 1 аж ахуйн нэгжтэй 460 га газрын гэрээ байгуулснаас 300 тн өвс бэлтгэж 20 тн өвсийг борлуулсан дүнтэй байна.

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “НАМРЫН НОГООН ӨДРҮҮД-ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ 2022” үзэсгэлэн худалдаанд сумаас “Сэлэнгэ таван хайрхан” дундын хоршоо, иргэн Б.Ариунзаяа, Н.Баасанжаргал нар төмс, хүнсний ногоо, даршилсан ногоо зэрэг 20 нэр төрлийн бүтээгдэхүүнээр, сумын брэнд бүтээгдэхүүний амталгаанд “Цахар иш” ХХК-ий талх, нарийн боовны дээжээр оролцлоо.



Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм 9 дүгээр сарын 01-ний өдөр Сант суманд ажиллаж төрийн албан хаагч, иргэдтэй уулзалт хийж сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж тулгамдсан асуудлын талаар санал солилцлоо.

2022-2023 оны хичээлийн жилд сумын 1-р цэцэрлэгт үндсэн бүлгийн сургалтад 120 хүүхэд хамрагдахаас 72 хүүхэд суралцаж хамрагдалт 60 хувьтай байна. Ерөнхий боловсролын сургуульд 12 бүлгийн 310 хүүхэд суралцаж байгаагаас 1-р ангид 29 хүүхэд элсэн суралцсан. “Үдийн хоол хөтөлбөр”-т 1-5-р ангийн 145 суралцагч хамрагдаж, дотуур байранд 60 суралцагч амьдарч байна.

#### **Сүхбаатар сум:**

Тагнуулын Ерөнхий газрын Сэлэнгэ аймаг дахь газрын албан хаагчид сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад Төрийн болон албаны нууцын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын талаар сургалт мэдээлэл хийж, тус сумын Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй нууцын бичиг баримтын хадгалалт хамгаалалттай танилцаж, зөвлөн туслах хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллалаа.

“ИДЭВХТЭЙ УРТ НАСЛАХЫН ТӨЛӨӨ ХАМТДАА” гэсэн уриатай бэлчир бүсийн ахмадуудын уулзалт өдөрлөг зохион байгуулж, Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумын ахмадын хорооны ахмад настнууд оролцож урлаг, спортын тэмцээн зохион байгууллаа.

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан “Хамтарсан баг” манай сумын “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаатай танилцан харилцан туршлага солилцож ажиллалаа.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх нь, хүүхдийн гарын ариун цэвэр” сэдэвт сургалтыг тус сумын Салхит 3 дугаар багийн 10-14 насны нийт 50 хүүхдийн зохион байгуулж хичээлийн хэрэгслийн дэмжлэг үзүүлж, хамтран ярилцаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Мөн тус байгууллагаас “ЭМЭГТЭЙЧҮҮД ХҮЧТЭЙ” сэдэвт сургалтыг тус сумын Буурхээр 8 дугаар багт зохион байгуулж, 14 эмэгтэй хамрагдсан.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Хөөрхөн зүрх” ТББ-аас зохион байгуулсан “Өөрийгөө хайрлахуй ба сэтгэцийн эрүүл мэндээ тордох нь” сэдэвт сургалтад тус сумын 8 багийн зорилтот өрхийн 75 эмэгтэй оролцсон.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтарч “Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн” худалдааг зохион байгуулж, тариалан эрхлэгч 14 иргэн оролцож 10.740.000 төгрөгийн борлуулалт хийсэн. Мөн Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд тус сумын төмс, хүнсний ногоо тариалдаг 8 иргэн оролцлоо.

Сумын хэмжээнд 283 өрх, 2 аж ахуйн нэгж нийтдээ 72 га-д төмс, хүнсний ногоо 48 га-д тариалж ургац хураалт төмс 31, хүнсний ногоо 87 хувьтай явагдаж байна.

Байгалийн хадлан 2083 тн, үйлдвэрийн тэжээл 741 тн, давс хужир шүү 93 тн хэрэгцээтэй байгаа ба хэрэгцээт хадланг сумын малчин мал бүхий иргэд Шаамар, Алтанбулаг, Зүүнбүрэн сумдын нутаг дэвсгэрээс 1278 тн байгалийн хадлан бэлтгэсэн байна. Үйлдвэрийн тэжээл 200 тн, давс хужир, шүү 28 тн бэлтгэсэн ба сумын малчид, мал бүхий иргэд 2022-2023 оны мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангалт 61,4 хувийн биелэлттэй байна.

#### **Түшиг сум:**

Түшиг сумын хэмжээнд нийт 3802 тн өвс бэлтгэхээс 09 дүгээр сарын байдлаар 3840 тн өвс бэлтгээд байна.

Сумын хэмжээнд 09 дүгээр сард хээлтэгч, хээлтүүлэгч малын судалгааг авахад нийт хээлтэгчийн тоо 24956 үүнээс гүү 1104, үнээ 3189, хонь 12142, ямаа 8521 байна. Тохироо ногдох хээлтүүлэгчийн тоо нийт 664, үүнээс азарга 122, бух 128, хуц 243, ухна 171 байна.

Хуурайшилтын үе эхэлсэн тул мод бэлтгэлийн ажлыг бүрэн зогсоосон. “ММЭ Түшиг” ХХК, “Мойлт нуга” ХХК-ий 3 талбайд мод бэлтгэл болон гарал үүслийн гэрчилгээгээр гадагш тээвэрлэж байгаа модонд хяналт тавьж эрхийн бичиг, гарал үүслийг хянаж ажиллалаа.

БОАЖС-ын А/372 тоот тушаалын дагуу суманд 332 тн самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар олгосны дагуу ойн дагалт баялаг ашиглах эрх бүхий мэргэжлийн байгууллага “Их үрчин” ХХК, “Норд роуд” ХХК, “Түмэн хурын хишиг” ХХК, “Мотума” ХХК, “Арвин ачит” ХХК- иуд тус бүр 40,04 тн, “Идэр-Чандмань” ХХК 21 тн самар бэлтгэж түүхээр гэрээ байгуулж 254,912,000 төгрөгийн орлогыг одоогоор төвлөрүүлээд байна.

Сумын Засаг даргын А/89 тоот захирамжийн дагуу байгалийн дагалт баялаг, түлээний модны бэлтгэл, тээвэрлэлтэд 09 дүгээр сарын 05-20-ны хүртэл хугацаанд Хил хамгаалах байгууллага, Цагдаагийн хэсэгтэй хамтран постод 24 цагаар гарч ажиллалаа.

Ан амьтан агнах тоо хэмжээг агнуурын бүс нутаг бүрээр тогтоосны дагуу 6 ширхэг зэрлэг гахай, 2 ширхэг бор гөрөөс агнах эрхийн бичгийг олгож, хяналт тавьж ажиллалаа.

#### **Хушаат сум:**

“Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, “Эерэг сэтгэлгээний давлагаа”, “Эртэч Монгол” ТББ-уудын хамтран зохион байгуулсан “Эерэг сэтгэлгээ-Хувь хүний хөгжлийн цогц сургалт”-д 1 албан хаагч хамрагдаж “Сургагч багш”-аар бэлтгэгдлээ.

Сумын Засаг даргын 2022 оны А/78 тоот захирамжаар Мөнхтолгой 2 дугаар багийн Хашаат, Нарс толгой, Наранбулаг, Даагат 1-р багийн Зүрт, Ташир гэх байршлуудад зөвшөөрөлгүй өвөлжөө, хаваржаа барьж газар ашиглаж байсан 6 иргэний өвөлжөөг албадан буулгаж зөрчлийг арилгасан.

Дархан-Сэлэнгийн автозамаас Хушаат сумын төв хүртэлх 19.9 км автозамын зураг төслийн ажлыг хүлээн авлаа.

Сумын төсвийн хөрөнгөөр Цагдаагийн хэсгийг унаажуулж ард иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг түргэн шуурхай гүйцэтгэх нөхцөлийг хангалаа.

Хушаат сумын Хушаат хэмээх газарт хүчтэй салхины улмаас 8 өрхийн гэр нурж хохирол учирсан ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улаан загалмайн анхан шатны нэгжээс хүргүүлсэн мэдээлэл, хүсэлтийн дагуу аймгийн Улаан загалмайн Нийгэмлэгээс нэр бүхий 8 өрхөд тусламж үзүүллээ.

Сумын Ахмадын хорооноос зохион байгуулж буй “Намрын өгөөж-Настны хишиг” үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж нийт гар урлал, төмс, хүнсний ногоо, даршилсан ногоо, сүү сүүн бүтээгдэхүүнээр иргэдэд үйлчиллээ.

#### **Хүдэр сум:**

Сумын Засаг даргын 2022 оны А/58 тоот захирамж болон “Цэмцгэр Хүдэр” аяны хүрээнд бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, төр төсвийн байгууллагын 67 ажилтан албан хаагч, аж ахуйн нэгж хувийн хэвшлийн 45 ажилтан, 1, 2 дугаар багийн 38 иргэн нийт 150 хүний бүрэлдэхүүнтэйгээр 5га талбайг цэвэрлэлээ.

“Харилцааны гайхамшиг” ТББ-тай хамтран “Хувь хүний манлайлал менежментийг хөгжүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх нь”, “Гэр бүлийн харилцаа байгууллагын амжилтад нөлөөлөх нь” сэдэвт сургалтуудыг Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн багш, ахлах ангийн сурагчид, эцэг эх, зохион байгуулж нийт 275 иргэн хамрагдлаа.

Сумын хэмжээнд 394 малчин, мал бүхий өрх, 2 аж ахуйн нэгжийн нийт 47347 толгой мал буюу адуу 5067, үхэр 13820, хонь 15346, ямаа 13114 өвөлжих төлөвтэй байна.

Сумын Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуй нэгж, 1 иргэний тариалангийн талбайд ургацын хэмжээ тогтоож ажиллалаа. Уг ажлын үр дүнд улаанбуудай 5599 га, рапс 550га, төмс 68 га, хүнсний ногоо 46 га-д тус тус тарилснаас улаанбуудай 6748,1 тн, рапс 605 тн, төмс 680 тн, хүнсний ногоо 480 тн ургац авах төлөвтэй байна.

Сумын хэмжээнд 09 дүгээр сарын байдлаар төмс 22 га-аас 300 тн, шар манжин 1 га-аас 25тн, сармис0,03 талбайгаас 500кг, сонгино 0,5 га-аас 8,5тн хураан авсан.

Аймгийн Засаг даргын “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” А/197 дугаар захирамж, сумын Засаг даргын А/41 дугаар захирамжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж, мал амьтны гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мал амьтны төлөвлөгөөт ажлыг МЭҮН-тэй хамтран мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт ажилд мал сүргийг бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд тугал 2400, бог малын төл 5200 толгой хамруулан дархлаажуулж, “Бруцеллёзын тандалт 2022” тандалт шинжилгээнд бух 97, хуц 55, ухна 50 толгойг хамруулан, асуумж судалгаа авч ажиллалаа.

Хуш модны самрыг хамгаалах, зохистой ашиглах, хууль бус ашиглалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль, дүрэм журам стандартыг Хүдэр сум ойн анги, Хүдэр зар цахим хуудсаар дамжуулан 10 удаа хүргэж давхардсан тоогоор 489 хүн, сэрэмжлүүлэг, зөвлөмж, мэдээ мэдээлэл, шторкыг 11 удаа хүргэж давхардсан тоогоор 581 хүн, нийт 21 удаа мэдээлэл оруулж давхардсан тоогоо 1070 хүн хандалт өгч хамрагдсан байна.

#### **Цагааннуур сум:**

Ерөнхий боловсролын сургууль хичээлийн шинэ жилийг 35 бүлэг, 1043 суралцагч, 72 багш ажилчинтай, 1-р цэцэрлэг 162 хүүхэд, 31 багш ажилчинтай, 2-р цэцэрлэг өдрөөр 202 хүүхэд, хувилбарт сургалтаар 60, нийт 262 хүүхэд, 30 багш ажиллагсадтайгаар эхлүүлсэн.

БНСУ-ын Жежү мужийн боловсролын газар, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын хамтын ажиллагааны хүрээнд Ерөнхий боловсролын сургуульд компьютерын иж бүрэн кабинет хүлээлгэн өгсөн.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ?”, “Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэрхэн хаана хандах вэ?”, “Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн хүчирхийлэл болон үе тэнгийн дарамт, дээрэлхэлт, анхан шатны тусламж хэрхэн үзүүлэх вэ?” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, Малын тоо толгойн албан татварын 168 сая төгрөгийн хөрөнгөөр сумын төвлөрсөн хогийн цэгийг 840 м урт, 3 м өндөр төмөр тороор хашаажуулж, 360 градусын хяналтын камерыг суурилуулсан.

Спорт цогцолборын их засварын ажлыг аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 297 сая төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн.

Суманд үйл ажиллагаа явуулдаг 15 үйлчилгээний байгууллагын 1479 м2 талбайд “Сэлэнгэ ариутгал” ХХК ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Цагааннуур сумын уугуул Монгол Улсын Ардын эмч, гавьяат эмч, Доктор профессор Э.Санжаагийн үүсгэн байгуулсан “Орбита” нүдний эмнэлгийн мэргэжлийн эмч нар үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж, нийт 176 иргэн хамрагдаж, үүнээс 40 иргэнд нүдний шил үнэ төлбөргүй хийж өгсөн.

Улаанбуудайн ургац хураалт 5242 га талбайгаас 6757,8 тн, тосны ургамал 170 га талбайгаас 105 тн ургац хураан авч сумын хэмжээнд ургац хураалт 17 хувьтай явагдаж байна.

2022 оны өвөл 200 мянган толгой мал өвөлжих ба малчин, мал бүхий 600 өрх өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 8092 тн өвс хураан авсан.

#### **Шаамар сум:**

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 сарын 19-ний өдрийн А/15 тоот захирамж “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн эрчимжүүлэх” ажлын хүрээнд Шаамар сум Дулаанхан тосгоны төр төсвийн нийт 32, худалдаа үйлчилгээний 18 байгууллагын нийт 21586,2 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Гэр бүл хүүхдэд ээлтэй орчин байх”, “Монгол бичиг” сумын дэд хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу сургалтыг Даваа гариг бүр хийж тогтмолжуулсан.

2022-2023 оны хичээлийн жилд Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 3 цэцэрлэгт 82 багш ажилтантай, 335 хүүхэд суралцаж хамрагдалт 95.4 хувьтай, Ерөнхий боловсролын байгууллагад 2 сургуульд 77 багш ажилтан, 744 хүүхэд суралцаж, хамрагдалт 91.6 хувьтай, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд 32 багш ажилтан, 120 суралцагч суралцаж байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны “2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 02 албан тоотын дагуу сумын нийт 150 иргэнд 1715 га талбайд хадлангийн газрыг олголоо.

09 дүгээр сарын байдлаар 1300 га талбайд улаанбуудай тариалснаас 1300 тн, 81 га талбайд ногоон тэжээл тариалснаас 259,2 тн, 220 га талбайд рапс тариалснаас 154 тн, 59 га талбайд төмс тариалснаас 885 тн, 156,5 га талбайд хүнсний ногоо тариалснаас 2314,3 тн ургацыг хураан авсан.

Улаанбаатар хотод жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Намрын Ногоон Өдрүүд-Үндэсний Үйлдвэрлэл 2022” нэгдсэн арга хэмжээнд Шаамар сумын 22 ногоочин, 2 хоршоо, 1 мод үржүүлгийн газар оролцож хүнсний ногоо, хүнсний бүтээгдэхүүнээр нийслэлийн иргэдийг хангаж нийт 70.000.000 төгрөгийн борлуулалтыг хийсэн. Мөн Шаамар сум /Шилдэг сум/, сумын иргэн Д.Баасансүрэн Жимс, жимсгэнийн суулгацаар шилдгээр шалгарлаа.

УИХ-ын дарга Г. Занданшатар Шаамар суманд ажиллалаа. Тэрээр сумын Засаг даргын хэрэгжүүлж байгаа “Түрээсийн хүлэмж” хөтөлбөрийг сайшааж нарийн ногоог тарьж ургуулж байгаа ногоочдод амжилт хүслээ.